



НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хийсэн нийцлийн аудитын тайлан



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ОРЛОГЫН
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН**

2014 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар		Товчилсон үгийн жагсаалт	2
НАГ-ын дарга Б.Алтанзул		Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Аудитын менежер З.Ариунзаяа		Ерөнхий мэдээлэл	4
		Бүлэг 1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого бүрэн төвлөрөөгүй байна	5
Ахлах шинжээч	Я.Наранцэцэг	1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлж чадаагүй байна.	5
Шинжээч	Ш.Наранбаатар	1.2. ХЭДС-ийн орлогын дийлэнх хувийг гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр эзэлж байна.	6
		Бүлэг 2 Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн хөрөнгө бүрэн зарцуулагдаагүй байна.	8
2014 оны 5 дугаар сар		2.1 Хэрэгжсэн төсөл хөтөлбөрт аудитаар илэрсэн зөрчлийн талаар	8
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn		Бүлэг 3 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл болон орон нутгийн салбар зөвлөл, дотоод хяналт шинжилгээний талаар	20
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.		3.1. ХЭҮЗ болон салбар зөвлөл нь сангийн орлого зарлагын байдалд хяналт тавьж ажиллаагүй байна.	20
		3.2. Дотоод хяналт, шинжилгээ хийгдэж байгаа ч хангалтгүй.	
ХАЯГ: Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс		Дүгнэлт	23
		Зөвлөмж	24
		Холбогдох байгууллагын санал	25
		Саналд өгсөн тайлбар	28
		Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	29

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ХЯ	Хөдөлмөрийн яам
ХЭҮТ	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв
ГИХАЭГ	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар
АХГГГАХМАТХ	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХЭДТХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
ГЭЗБТХ	Гадаадын эрх зүйн байдлын тухай хууль
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ТББ	Төрийн бус байгууллага
БИТ	Бизнес инкубаторын төв
ХБ	Хөдөлмөрийн бирж
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХ	Хөдөлмөрийн хэлтэс
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭСЗ	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ЖДҮТ	Жижиг дунд үйлдвэрийн төв
ХБХ	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
ХЗЗМНС	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**Аудитын нэр**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн

Аудитын код

УАГ-НАГ/2014/01-НА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны “Аудитын сэдэв батлах” тухай 3 дугаар тогтоол, Үндэсний аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

ХЭДС-д төвлөрүүлэх орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, хуваарилалт зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон салбар зөвлөл хэрхэн ажиллаж байгаа эсэх;
- Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байгаа эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад Хөдөлмөрийн яам, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, аймаг, нийслэлийн Хан-уул дүүрэг, Баянзүрх дүүрэг, Баянгол дүүргийн ХХ тус тус хамрагдав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- ХЭДС-ийн орлогын бүрдүүлэлтийг түүвэрлэх;
- Холбогдох эрхийн актыг судлах;
- ХЭДС-ийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой судалгаанд дүн шинжилгээ хийх;
- ХЭДС-ийн холбогдох бусад байгууллагын ажилтнууд болон бусад байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх;
- Гадаадаас авсан ажиллах хүчний судалгааг гаргуулж дүн шинжилгээ хийв.

Төрийн хяналт шалгалтын стандартын дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 375 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг тус тус баталжээ.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2012 оны 55 дугаар захирамжаар Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсантай холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийн “Үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

ХЭҮЗ-ийн 2012 оны 4 дүгээр тогтоолоор 2013 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдуулан хүснэгтэд дурьдсан нэр бүхий төсөл хөтөлбөрүүдийг баталж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

№	Хөтөлбөрийн нэр
1	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
2	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөр
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр
5	Ажил олгогчийг дэмжих хөтөлбөр
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
7	40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
8	Эзэнтэй монгол хөтөлбөр
9	Хөдөлмөрийн салбарын байгууллага, ажилтаны чадавх сайжруулах, бэхжүүлэх төсөл

ХЭДС-ийн хөрөнгийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах, мэргэжлийн сургалтад хамруулах, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих, хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийг мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулдаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 21 аймаг, 9 дүүргийн ХХ, Хөдөлмөрийн төв бирж, нийслэлийн Хөдөлмөрийн газар болон гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хамрагддаг байна.

Бүлэг 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого бүрэн төвлөрөөгүй байна

1.1 ХЭДС-ийн орлого нь улсын төсвийн хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөр болон бусад эх үүсвэрээс бүрддэг.

1.2 Санд төвлөрсөн нийт орлогын 60 хувийг гадаад иргэдийн ажлын байрны төлбөр, 30 хувийг жижиг зээлийн эргэн төлөлт, бусад хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны орлого эзэлж байна.

1.3 Сангийн хөрөнгө бүрдүүлэлтийг төлөвлөхдөө 2013 онд 87.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 79.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 7.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлж чадаагүй байна

1.4 Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг баталсан байна.

	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо (бүсээр)	50 хүртэлх ажиллагчтай	51-ээс дээш ажиллагчтай
1	Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймаг	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 40 хувиар	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиар
2	Бусад аймаг	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар	

1.5 Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 20-иос дээш ажилтантай 2988, 50-иас дээш ажилтантай 1802 нийт 4790 ААН 25 ажилтан тутамд нэг ХБИ ажиллуулах хэрвээ ажиллуулаагүй бол ЗГ-ын тогтоолын дагуу сар бүр төлбөр төлөх тухай заасан байна. Гэтэл ХЭДС-д ХБИ ажиллуулаагүйн төлбөрт улсын хэмжээнд 392.0 сая төгрөг төвлөрсөн байна.

1.6 ХЭДС-д хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрөөс олсон орлогыг сүүлийн 5 жилийн байдлаар үзүүлбэл. Үүнд:

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	(сая. төг) 2013
ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн Орлого	566	685.5	374.1	300	392.2

1.7 Говь-Алтай аймагт хөгжлийн бэрхшээлтэй одой иргэнийг ажиллуулаагүйн төлбөр болох 48.5 сая төгрөгийг аан, албан байгууллагаар төлүүлэхээр судалгаа гаргаж төлөвлөсөн боловч 126.3 мянган төгрөгийн төлбөрийг оруулан үлдэгдэл 48.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй байна. Мөн бусад аймгийн тайланд энэ талаар тусгаагүй байна.

1.8 ЗГ-ын 26 дугаар тогтоолыг аж ахуйн нэгж, байгууллагуудаас ХБИ-ийг ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлж чадаагүй. ХЭДС-ийн орлогын дөнгөж 0.45 хувийг бүрдүүлж байгаа нь сангийн хөрөнгө төвлөрүүлэлтэд нөлөөлж байна.

ХЭДС-ийн орлогын дийлэнх хувийг гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр эзэлж байна

1.9 Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар гадаад иргэдийн ажлын байрны төлбөрт 65.1 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөө баталж, гүйцэтгэлээр 48.7 тэрбум төгрөг буюу 11.4 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

1.10 Монгол Улсад гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах асуудал АХГГГАХМАТХ-ийн дагуу зохицуулагддаг ба гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх зам, барилгын ажил болон бусад үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотойгоор гадаадаас авах ажиллах хүч жилээс жилд өсөн нэмэгдсэн байна. Үүнийг сүүлийн 4 жилийн байдлаар харуулбал:

№	Тайлбар	2010	2011	2012	2013
1	ХЭЗ авсан нийт иргэн	18494	30566	27129	27191

1.11 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монгол Улсад нийт 101 орны 8863 гадаадын иргэн холбогдох зөвшөөрлийн дагуу хөдөлмөр эрхлэж байна.

1.12 Хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн 2844 буюу 32.1 хувь нь БНХАУ-ын иргэд, 2123 буюу 24.0 хувь нь БНАСАУ-ын иргэд, 672 буюу 7.6 хувь нь ОХУ-ын иргэд, 549 буюу 6.2 хувь нь БНСВУ-ын иргэд, 552 буюу 6.2 хувь нь БНСУ-ын иргэд, 354 буюу 4.0 хувь нь АНУ-ын иргэд, үлдэх хувийг бусад улсын иргэд эзэлж байна.

1.13 ХЭДС-д төвлөрсөн гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогыг сүүлийн 5 жилийн байдлаар үзүүлбэл. Үүнд:

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013
Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр	12682.4	24237.1	62287.8	53466.7	47072.3

(сая.төг)

1.14 Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 60 дугаар тогтоолоор дараах компаниудыг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн байна. Үүнд:

	Байгууллагын нэр	Хугацаа	Квот чөлөөлсөн тоо	Ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн тоо	Сар бүр төлөх төлбөр /сая. төг/
1	БНСУ-ын \Бексок\ констракшн компани	2013.02.23	177	177	49701.6
2	Жянши уотер энд хайдропауэр ХХК	2013.02.23	360	360	101088.0
3	Халла инженеринг энд констракшн	2013.02.23	360	360	101088.0
4	Хунан констракшн инженеринг компани	2013.02.23	6	6	1684.0
5	Чайна Гео-инженеринг корпораци	2013.02.23	52	52	14601.6
6	Чайна жиансу жианда констракшн ХХК	2013.02.23	902	902	253281.0

7	Чайна машинару индустри констракшн	2013.02.23	280	280	78624.0
8	Чайна рейлвей ферст групп компани	2013.02.23	408	408	114566.4
9	Эрдэнэс таван толгой	2013.09.28	500	500	140400.0
	Нийт		3045	3045	855036.0

1.15 АХГГГАХМАТХ-ийн дагуу Засгийн газар “2013 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” 192 дугаар тогтоол гарган Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн 2013 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг салбар болон дүрмийн сан, хөрөнгө оруулалтын хэмжээ, нийт ажиллагчдын тоог үндэслэн баталжээ.

1.16 Засгийн газрын тогтоолоор 2013 онд 27191 гадаадын иргэнд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн урилга олгож, 15989 гадаадын иргэн ирснээс 3045 иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн байна.

БҮЛЭГ 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн хөрөнгө бүрэн зарцуулжээ

2.1 ХЭДС 2013 онд батлагдсан төсөл, хөтөлбөрт 28.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 22.4 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулж, хөдөлмөрийн салбарын байгууллага, ажилтны чадавх сайжруулах, бэхжүүлэх төсөлд 3.0 тэрбум төгрөг, үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд 17.0 тэрбум, жижиг зээлд 13 тэрбум төгрөгийг зээлд, сум хөгжүүлэх санд 24 тэрбум төгрөг зэрэг нийт 79.4 тэрбум төгрөг зарцуулжээ.

2.2 ХЭДС-ийн хөрөнгийг хуваарилахдаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээ томоохон хэмжээний төсөл, хөтөлбөрт хамрагдах хүн, зарцуулах хөрөнгө, мөн аймаг, дүүргийн бүртгэлтэй ажилгүйчүүд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоог харгалзан үздэг байна.

2.3 МУЗГ-ын “Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай” 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 250 дугаар тогтоолоор ХЭДТХ-ийн 23.1.5¹, 23.1.11²-д заасныг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дүрэмт хувцсыг 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн үндэсний үйлдвэрүүдээс нийлүүлэхээр тогтоол гаргаж ХЭДС-ийн хөрөнгөнөөс 17.0 тэрбум төгрөгийг сурагчийн дүрэмт хувцасны үйлдвэрлэл эрхлэгчдэд 2013 онд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр жилийн 7 хувийн хүүтэй 2 жил хүртэл хугацаатай хөнгөлттэй зээлээр олгожээ.

Хөдөлмөрийн салбарын байгууллага, ажилтны чадавхи сайжруулах зорилгоор төсөл хэрэгжүүлсэн байна

2.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1.10³ дугаар зүйл, мөн хуулийн 16⁴, 18⁵, 19⁶, 23.1.9⁷ дүгээрт тус тус заасныг үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын мэдээллийн сүлжээг бүрдүүлэх болон техник хэрэгслээр хангах Мөн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл хөтөлбөрийн хүрээнд уг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

2.5 ХЭДС-ийн 2013 оны төсвийн хуваарийг ХЭҮЗ-ийн хурлаар хэлэлцсэн бөгөөд энэхүү хурлаар “Салбар байгууллага, ажилтны чадавх сайжруулах, бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлэхийг дэмжиж төслийн хүрээнд хөдөлмөрийн хэлтсүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн асуудлуудыг багтаасан хөдөлмөрийн салбарын шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, автомашиныг бэлтгэхэд хөрөнгө хуваарилах асуудлыг ХЭДС-ийн 2013 оны төсвийн хуваарьт тусгах шийдвэр гаргаж аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтсүүдийн 2013 оны төсвийн хуваарьт 3.0 тэрбум төгрөгийг тусган хэрэгжүүлсэн байна. Энэ нь ХЭДС-ийн тухай хуулийн 23.3⁸ дахь заалтыг зөрчсөн байна.

1 ажил олгогчийг дэмжих;

2 хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх.

3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх

4 Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн тогтолцоо нь бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, ХЭ-ийн бүртгэл мэдээллийн сүлжээ, түүний программ хангамж болон техникийн хангамж, мэдээлэл цуглуулах, түгээх үйлчилгээ мэдээллийн эх үүсвэрээр бүрдэнэ.

5 Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээ нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, хамгаалах, түүнээс мэдээлэл түгээх, цахим хуудас, түүнд суурилсан программ болон техник хангамж, мэдээллийн бусад арга хэрэгслээс бүрдэнэ.

6 Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны болон аюулгүй байдал, хамгаалалтын журам, стандартыг тогтоох, хяналт тавих, программ болон техник хангамжийг хөгжүүлэх чиг үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

7 хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх

8 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Төслийн хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлсэн “Саммит” ХХК болон ажлын өрөөний тавилга нийлүүлсэн “Хашхан” ХХК бэлтгэн нийлүүлэхдээ гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн зөрчил гаргасан.

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

2.6 Уг хөтөлбөрийн зорилго нь ажил олоход хүндрэлтэй иргэн болон сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн иргэдэд зайлшгүй хэрэгцээтэй багц үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байна.

2.7 Хөтөлбөрт нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэн 1059, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 284, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас хүүхэд 8, хорих ангиас суллагдсан иргэн 362, зургаан сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн 675, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд 165 буюу нийт 2553 ажил олоход хүндрэлтэй иргэн хамрагдсан байна. Энэ үйл ажиллагаанд тус сангаас 413.1 сая төгрөг зарцуулжээ.

2013 онд хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Зөрүү /сая.төг/
Төлөвлөсөн зардал /сая.төг/	Хамруулсан хүний тоо	Гүйцэтгэсэн зардал /сая.төг/	Хамруулсан хүний тоо	
498.7	1867	413.1	2553	85.6

2.8 Мөн хөтөлбөрт төлөвлөгдсөн сургалт, зөвлөгөө, мэдээлэл зэрэг үйл ажиллагаанд дээрх хөрөнгийг зарцуулсан боловч хөдөө орон нутагт нэг бүрчлэн хүрч үйл ажиллагаа явуулж чадаагүйгээс 85.6 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Хөтөлбөрийн үр дүнд хөтөлбөрт хамрагдсан нийт иргэдийн 46.4 хувь буюу 1178 иргэн ажлын байранд зуучлагдсан мөн иргэдийг аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж мэдээллийн баазыг бий болгожээ.

2.9 Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хэмжээнд гарсан зөрчлүүдээс дурьдвал:

- **Баян-Өлгий аймагт:** хөтөлбөрөөс 7 иргэнд 4800.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, амьдрал ахуйд нь тус дэмжлэг болсон ч хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй;
- **Булган аймагт:** Хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх, мэдээллээр хангахад төлөвлөгдөөгүй 800.0 мянган төгрөгийг ХЭДТХ-ийн 23.3-т заасан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин бичгийн хэрэгсэл, принтерийн хор зэрэг төлөвлөгдөөгүй зардал зарцуулсан байна.

2.10 Хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа байдлаас үзэхэд дараах бэрхшээл гарсан байна. Үүнд:

- Хөдөө сумдад болон нийслэлийн хороодод хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байхгүй байгаа нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан;
- Хөтөлбөрийн хүрээнд үзүүлж буй санхүүгийн дэмжлэг болох усанд оруулах, үс засуулах зэрэг үйлчилгээг иргэд таагүй хүлээж авч байсан;
- Хөдөө орон нутагт ажлын байрны захиалга ховор тул ажлын байранд зуучлах боломж хангалтгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

2.11 Энэхүү хөтөлбөрийн зорилго нь иргэнд богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх зарим арга хэмжээний хүрээнд иргэдийг ажилтай болгоход чиглэгдсэн байна.

2.12 Хөтөлбөрийн хүрээнд ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд иргэдийн өөрийн хэрэгцээтэй мэргэжлээр хүссэн сургалтын байгууллагыг сонгон суралцах нөхцөл, боломжийг хангах зарчмыг баримталж ажилласан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг дараах хэлбэрээр зохион байгуулсан байна.

- Мэргэжлийн болон давтан сургалт;
- Үйлдвэрлэл дээрх сургалт;
- Явуулын болон зайны, шавь сургалт;

2.13 2013 онд хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг дээрх гурван хэлбэрээр орон нутгийн хөдөлмөрийн хэлтсүүд болон нийслэлийн Хөдөлмөрийн газар зохион байгуулж нийт 17000 иргэнийг хамруулан ХЭДС-аас 4.4 тэрбум төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 3.5 тэрбум төгрөгийг зарцуулж 900.0 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

2013 онд хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Зөрүү /сая.төг/
Төлөвлөсөн зардал/сая.төг/	Хамруулсан хүний тоо	Гүйцэтгэсэн зардал/сая.төг/	Хамруулсан хүний тоо	
4400.0	14.500	3500.0	17.000	900.0

2.14 Сургалтад зарцуулах хөрөнгөөс хэмнэлт гарсан гол шалтгаан нь Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтаар үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжлийн болон үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулж, ажилгүй иргэд хамрагдсан нь нөлөөлсний зэрэгцээ мэргэжлийн ур чадварын шалгалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулахтай холбогдсон зардлуудыг дээрх төслийн хүрээнд гаргасан нь хөрөнгийг зарцуулалгүй үлдээх нөхцөл болжээ.

2.15 Хөтөлбөрийн үр дүнд:

- Мэргэжлийн сургалтад хамрагдсан нийт иргэдийн 55 хувь нь ажил олгогчийн захиалгаар суралцсан ба нийт сургалтад хамрагдсан иргэдийн 69.8 хувь сургалтын дараа байнгын ажлын байраар хангагдсан;
- Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдсан иргэдийн 80.8 хувийг мэргэжлийн ур чадварын шалгалтад хамруулж мэргэжлийн зэргийн үнэмлэх олгосон, нийт төгссөн иргэдийн 77 хувь нь тухайн ажил олгогчийн захиалгат ажлын байраар хангагдсан;
- Мэргэжлийн сургалтад хамрагдсан иргэдийн 78 хувь нь бүртгэлтэй ажилгүй иргэн байсан ба 17 хувь нь мэргэжилгүй, мэргэжилээ дээшлүүлэх шаардлагатай аж ахуйн нэгж байгууллагад ажилладаг иргэд байсан байна.

2.16 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад орон нутгийн хэмжээнд дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- **Говь-Алтай аймагт:** Сургалтад хамрагдсан АУЭХС-ийн 30 ажилтан, цэцэрлэгийн 20 туслах багш, 2 туслах тогооч нийт 52 ажилтай иргэдийг сургалтад хамруулан 6400.0 мянган төгрөгийг сургалтын төлбөрт зарцуулсан нь ХЭДТХ-ийн 7.1-д заасан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч хамрагдана” гэсэн заалтыг зөрчсөн;

- **Баян-Өлгий аймагт:** Сургалтын төвийн захирал М. Кадирбек нь Хөдөлмөрийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д. Маралханы төрсөн хүү бөгөөд энэхүү сургалтын төвөөр 2013 онд 6 удаа сургалт явуулж, 29 сая төгрөгийн сургалтын зардлыг тус сургалтын төвд шилжүүлсэн байна. Энэ нь нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн “7.2.4-т заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн;
- **Дархан-Уул аймагт:** Сургалтад хамрагдсан иргэдийн болон сургалтыг явуулсан байгууллагын НДШ-ийг төлөөгүй, сургалт явуулсан газрууд ажилтай хүн, оюутан, дээд мэргэжилтэй иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулсан зэрэг нийт 4.3 сая төгрөгийн зөрчлүүд илэрч байна;
- **Ховд аймагт:** Төсвийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийг сургалтад хамруулсан 360.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан;
- **Сүхбаатар аймагт:** Сургалтад 40 хүнийг хамруулсан боловч сургалтад хамрагдсан иргэдийн материалыг нөхөж бүрдүүлсэн, шалгалт авч чадамжийн гэрчилгээ олгоогүй, сургалтын чанар, үр дүнг тооцож, хяналт тавиагүй, сургалтыг гэрээний дагуу зохион байгуулаагүй, мөн сургалтын хөтөлбөр удирдамжийг зөрчиж сургалт явуулсан зэрэг нийт 38.0 сая төгрөгийн зөрчил гаргасан;
- ХЭҮЗ-ийн 4-р тогтоолын 2-р хавсралтын 5.9⁹ дэх заалтыг зөрчиж 11 сургалтын байгууллагаар мэргэжлийн болон давтан сургалт явуулж 34000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Дээрх зөрчлүүд нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹⁰ дэх заалтыг зөрчсөн байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

2.17 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь малчны мал маллах, аж ахуй эрхлэх үр чадвар, орлогыг нэмэгдүүлэх, малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн зохион байгуулалтыг сайжруулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх, малчин ажил олгогчийг урамшуулах зорилго бүхий зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн байна.

2.18 Хөтөлбөрт хамрагдаж буй малчинд 5.0 сая хүртэл төгрөгийг өрхийг малжуулах зорилгоор нэг удаа олгодог байна.

2.19 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах малчин өрх нь доорх шалгуурыг хангасан байх шаардлага тавьдаг. Үүнд;

- 40 хүртэлх насны 2-оос доошгүй гишүүнтэй өрх;
- 50-150 толгой малтай;
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн баазтай;
- Нийт санхүүжилтийн 25-аас доошгүй хувийг малчин өөрөө материаллаг байдлаар гаргаж, хөрөнгийн барьцааг гаргах ба энэ талаар аймгийн хөдөлмөрийн хэлтэс, сумын ЗДТГ-тай гурвалсан гэрээ байгуулсан иргэн.

⁹ Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв нь мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах мэргэжлийн сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах удирдамжийг баталж, сонгон шалгаруулалтын бүхий л үе шатанд ил тод нээлттэй байдлыг ханган зохион байгуулна. Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэсүүдэд сонгогдсон мэргэжлийн сургалтын байгууллагуудтай гэрээ хийж сургалтын үйл ажиллагааг санхүүжүүлэн хяналт тавьж ажиллана”

¹⁰ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана”

2013 онд хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Зөрүү /сая.төг/
Төлөвлөсөн зардал /сая.төг/	Хамруулсан хүний тоо	Гүйцэтгэсэн зардал /сая.төг/	Хамруулсан хүний тоо	
2300.0	450	2100.0	574	200.0

2.20 Мөн хөтөлбөрт заасан арга хэмжээ болох зөвлөгөө мэдээлэл өгөх, төрөл бүрийн сургалт зохион байгуулах мэргэшсэн байгууллагууд цөөн байгаа нь энэ чиглэлээр малчдад үйлчилгээ үзүүлэхэд сөргөөр нөлөөлж, хөрөнгийг зарцуулаагүй үлдсэн бөгөөд малчин ажил олгогчийг дэмжих арга хэмжээ нь тухайн ондоо үр дүнгээ тооцож олгох боломжгүй байснаас 200.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2.21 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд:

- Хөтөлбөрт хамрагдсан малчин өрх бүрийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд бүртгэж, 930 ажлын байр болж үүнээс 757 нь шинэ ажлын байраар бүртгэгдсэн;
- Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн сарын дундаж орлого хөтөлбөрт хамрагдах мөн үеэс 50.0-120.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Малчин өрхүүд мал аж ахуйн бус үйлдвэрлэл эрхлэх ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдаж, өвөлжөө болон боломжтой газруудад өрхийнхөө хэрэгцээний ногоо тариалах, хадлангаа хаших, өвөлжөө хашаа саравч засварлах ажлуудыг бусад төсөл хөтөлбөрөөр дамжуулан туслалцаа дэмжлэг авсан;
- Хөтөлбөрт хамрагдсан өрхүүд маллуулах арга хэмжээний хүрээнд сүргийн бүтцээ сайжруулж, малын тоо толгойгоо нэмэгдүүлжээ.

2.22 МХЭДХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.12.1¹¹-д заасны дагуу хөтөлбөрийн хүрээнд нийт 574 иргэнд санхүүгийн дэмжлэг олгосон байна.

2.23 Хөтөлбөрийн хэрэгжих явцад орон нутгийн хэмжээнд дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- **Говь-Алтай аймагт:** Алтай болон Дэлгэр сумын хөтөлбөрт хамрагдсан малчин өрх 2013 оны жилийн эцсийн “А” дансаар малгүй болсон, 4 иргэний хувьд нийт 117 малаар багассан ба нийт 30000.0 мянган төгрөгийн зөрчил гаргасан;
- **Өвөрхангай аймагт:** Малчны хөтөлбөрт хамрагдсан иргэдтэй 10 хувийг ХЭДС-д төвлөрүүлэхээр гэрээ байгуулан 2013 онд төсөвт 15900.0 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан;
Баян-Өлгий аймагт: Зах зээлийн ханшаас дээгүүр үнээр мал худалдан авсан, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөс баталж, дээрх албан тоотоор ирүүлсэн 18 малчны нэрсийг өөрсдөө дур мэдэн өөрчилж өөр 18 малчдыг хамруулж 5400.0 мянган төгрөгийг зөвлөх малчинд олгосон зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон болно. ямар нэгэн шалтгаангүйгээр иргэн З.Тилеужанд олгох ёстой байсан санхүүгийн нэг удаагийн дэмжлэгийг тус сумын иргэн А.Асылбект олгосон;
- **Сүхбаатар аймагт:** Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчдын зөвлөхөөр ажиллах 25 малчинтай 2013 оны 12-р сарын сүүлээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний биелэлт, үр дүнг тооцох хугацаа болоогүй байхад 7500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон;
- **Хөвсгөл аймагт:** Хөтөлбөрт хамрагдах шаардлагагүй олон малтай иргэдийг хамруулсан нь хөтөлбөрийн 2.1-д заасан 50-150 толгой малтай иргэн хамрагдана гэж заасныг зөрчсөн.

11 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөдөлмөрийн болон түнтэй адилтгах бусад гэрээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой санхүүгийн баримтыг үндэслэн нэг удаа олгоно”

2.24 Хөтөлбөрийн хэрэгжилтээс үзэхэд малчин ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд хамрагдах малчин ажил олгогч нь хөтөлбөрт хамрагдах малчны нийгмийн даатгалыг ажил олгогчийн зүгээс төлөх сонирхол бага байдаг байна.

Хөдөө орон нутагт ихэвчлэн бэлэн бус тооцооны хэлбэрээр гэрээтэй ажиллаж байгаа нь малчны зүгээс бэлэн мөнгөөр нийгмийн даатгал, татвараа төлөх нөхцөл, сонирхолыг бий болгохгүй байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

2.25 ХХЭНХ байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр нь хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэний аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэгддэг байна.

2.26 Бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг ХЭҮТ сонгон шалгаруулж, шалгарсан 75 байгууллагын үйл ажиллагааг нь санхүүжүүлсэн байна. Орон нутгийн хөдөлмөрийн хэлтсүүд хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулсан байна. Мөн жижиг зээл олгох арга хэмжээг орон нутгийн банкаар дамжуулан олгожээ.

Жижиг зээл олгосон арга хэмжээ, хамрагдсан иргэний тоо, санхүүжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлсэн үйлчилгээ	Төлөвлөгөө /сая.төг/	Хүний тоо	Гүйцэтгэл /сая.төг/	Хүний тоо	Зөрүү /сая.төг/
Жижиг зээл	8152.6	3077	5409.9	2433	2742.7
Санхүүгийн дэмжлэг	3968.5	2221	3869.9	2953	98.6
Бизнес инкубацийн үйлчилгээ	1855.0	20200	1578.7	30363	276.3

2.27 2013 онд жижиг зээл олгох хөрөнгийг Хөдөлмөрийн яамнаас арилжааны банкуудад байршуулах хугацаа хоцорсон учир 2742.7 сая төгрөгийн, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн баййгууллага, төвүүд орон нутагт цөөн байгаа нь санхүүгийн зарлагад нөлөөлж 276.3 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

2.28 Хөтөлбөрийн үр дүнд:

- Хөтөлбөрт хамрагдсан иргэн, төсөл хэрэгжүүлэгч хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдэж, хөтөлбөрийн үр дүнгээр санхүүгийн дэмжлэг авсан 1917 иргэн шинэ ажлын байраар хангагдсан ба 2276 иргэн жижиг зээлд хамрагдсанаар шинэ ажлын байртай болсон;
- 209 иргэн инкубацийн буюу бизнесийн хөгжлийн суурь үйлчилгээнд хамрагдаж хөдөлмөр эрхлэх боломжтой болсон;
- Энэ үйлчилгээ нь бизнесийн санаа олсон иргэнийг аж ахуй эрхлэх сургалтад хамруулах, төсөл боловсруулахад нь туслах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах хэлбэрээр зохион байгуулагддаг байна.

2.29 Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хэмжээнд дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- **Говь-Алтай** аймгийн хөдөлмөрийн хэлтэс ХХЭ болон НХ-ны хооронд байгуулсан гэрээг зөрчиж 23 төслийн 69000.0 мянган төгрөгийг төсөлд зарцуулсан ч ажлын байр бий болоогүй;
- **Баян-Өлгий аймагт:** “Тасымал микро” хоршоо байгуулж 6 жил гаруй үйл ажиллагаа явуулж ирсэн Өлгий сумын 5-р багийн иргэнийг энэхүү хөтөлбөрт хамруулж 9000.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй санхүүгийн дэмжлэг олгожээ. Энэ нь ХХЭБНХБИДХ-ийн 4.2-т заасан “Аж ахуй эрхлэлтийн сургалтад хувиараа болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэдийг хамруулах ба сургалтын дараа үйл ажиллагааг нь дэмжин нэг гишүүнд нэг сая төгрөгөөр тооцож 10 сая төгрөг хүртэлх төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг дараах бичиг баримтыг үндэслэн олгоно” гэснийг зөрчсөн;
- **Сүхбаатар аймагт:** Баруун-Урт суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдээс түүвэрлэн 8 иргэнийг хамруулан шалгахад санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хөрөнгийг ямар тоног төхөөрөмж, материалд зарцуулсан нь баримт нотолгоогүй, үйл ажиллагаа нь түр зогссон, гэрээнд заасан хугацаанд төслийн хэрэгжилтийн явцын тайлан гаргаагүй, Санхүүгийн дэмжлэгийн үйлчилгээг үзүүлэх аж ахуйн нэгж, иргэнийг сонгон шалгаруулаагүй 31.2 сая төгрөгийн зөрчил;
- **Булан аймагт:** Фермер эрхлэгчдэд сургалтын төлбөрт нэг хүний зардал болох 700.0 мянган төгрөгийг сүү үйлдвэрлэл хөгжлийн төвд илүү шилжүүлсэнийг буцааж дансанд оруулаагүй зөрчил;
- **Сэлэнгэ аймагт:** Жижиг зээлд хамрагдсан 21 иргэний 25.0 сая төгрөгийн зээлийн гэрээг Төрийн банкны төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулаагүй.

2.30 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээлтэй асуудлыг дурьдвал:

- Санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэдийн нэг ажлын байранд ногдох санхүүжилтийг багасгаж, олон иргэдэд хүртээх зорилгоор олгосон нь бодит хэрэгцээг хангаж чадаагүй;
- Нэг ажлын байрыг 1.0 сая төгрөгөөр тооцсон нь төв суурин газарт жижиг зээл олгож ажлын байр бий болгож байгаа бодит тооцоотой нийцэхгүй;
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд шинэ технологийн сургалт, зөвлөгөө мэдээлэлээр хангах үйлчилгээ үзүүлэгч мэргэшсэн байгууллагууд, төвүүд орон нутагт байхгүй байна.

Ажил олгогчийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

2.31 Ажил олоход хүндрэлтэй иргэнд ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих бий болгосон ажлын байранд тухайн иргэнийг тогтвортой ажиллахыг урамшуулах зорилго бүхий санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг байна.

2013 онд хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Зөрүү /сая.төг/
Төлөвлөсөн зардал/сая.төг/	Хамруулсан хүний тоо	Гүйцэтгэсэн зардал/сая.төг/	Хамруулсан хүний тоо	
1720.0	1409	666.6	386	1053.4

2.32 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа урт, тавигдах шаардлагууд өндөр байгаа тул хөтөлбөрийн шаардлагыг хангаж буй ажил олгогч цөөн байна. Ялангуяа хөдөө орон нутаг, алслагдсан сум хороонд хөтөлбөрт хамрагдах ажил олгогч бага байна.

2.33 Хөдөө орон нутагт тогтвортой ажлын байртай, хөдөлмөрийн гэрээ хийж ажиллах хувийн хэвшлийн ажил олгогчид цөөн, улирлын чанартай ажлын байр

нилээд байгаа нь тогтвортой нэг жилээс дээш хугацаагаар гэрээ хийх боломжгүй байна.

2.34 Хөтөлбөрт төсвийн байгууллагууд хамрагдах боломжгүй байна. Хөтөлбөрт хамрах хүрээг тодорхойлохдоо төрийн өмчид улсын үйлдвэрийн газар, төсвөөс санхүүждэг байгууллага, ажил олгогч малчин, мал бүхий иргэнд хамаарахгүй байхаар тусгасан байна.

Эдгээр шалтгаанаас болж 1053.4 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2.35 Хөтөлбөрийн үр дүнд:

- Хөтөлбөрт хамрагдах ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажилд авч ажиллуулах гэрээтэй иргэдийн мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд оруулж гэрээ байгуулсан. Урьдчилсан байдлаар 2014 онд гэрээгээ дүгнэж ажиллахаар 911 ажил олоход хүндрэлтэй иргэн 460 ажил олгогч байгууллагатай гэрээ хийсэн;
- Хөтөлбөрт хамрагдсан ажил олоход хүндрэлтэй иргэнийг авч ажиллуулах ажил олгогчийн сонирхолыг бүрдүүлэх зорилгоор хөтөлбөрөө өдөрлөг, яармаг, нээлттэй хэлэлцүүлгийн үед сурталчлах, иргэдийг ажил олгогчдод танилцуулах, ярилцлага хийх нөхцлөөр хангах болон бусад хөтөлбөрүүдээр дамжуулан холбоотой ажиллахад анхаарсаны дүнд хөтөлбөрт хамрагдах иргэд, ажил олгогчдод хандах хандалт өмнөх жилээс 30-50 хувиар нэмэгдсэн судалгаа гарчээ.

2.36 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад орон нутгийн хэмжээнд дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- **Баян-Өлгий аймагт:** Сагсай сумын ахлах сургууль нь нэг багшийг биологийн багшаар ажиллуулсны төлөө сангаас 1684.8 мянган төгрөгийн санхүүгийн нэг удаагийн дэмжлэг олгосон нь ажил олгогчийг дэмжих тухай хөтөлбөрийн 30.3-т “Хөтөлбөр нь төрийн бус байгууллага болон хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэрээс бусад төрийн өмчит улсын үйлдвэрийн газар, төсвөөс санхүүждэг байгууллага, ажил олгогч малчин, мал бүхий иргэнд хамаарахгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн;
- **Налайх дүүрэгт:** Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх заалтаар тогтоосон хувиас давсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан 25-аас дээш ажилтантай ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно гэж заасныг зөрчин. 2012 оны 4 дүгээр сараас 12 сар хүртэлх 8 сарын хугацаанд ажиллуулсан, урамшуулал олгох шалгуурыг хангаагүй байхад Уран гар ХХК-д Налайх дүүргийн ХЭДС-аас 1684.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон;
- **Сүхбаатар дүүрэгт:** “Асралт баянхайрхан” ХХК нь Д.Урангоо, С.Нямсүрэн нарыг 2013 оны 1 дүгээр сараас ажилд авч, нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр баримт бүрдүүлэн Чингэлтэй дүүргийн ХЭДС-аас ажил олгогчийг дэмжих хөтөлбөрөөр 3782.0 мянган төгрөгийн урамшуулал авсан байна. Гэтэл Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээс шалгахад иргэн Д.Урангоо, С.Нямсүрэн нарын нийгмийн даатгалын шимтгэлийг 2013 оны 1 дүгээр сараас эхлэн 12 сарын хугацаанд “Этэрнал Блю Скай” ХХК гэх өөр байгууллага төлж, ажлын байраар хангасан байна.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа урт, тавигдах шаардлагууд өндөр байгаа тул хөтөлбөрийн шалгуурыг хангаж буй ажил олгогч маш цөөн байна. Хөдөө орон нутаг, алслагдсан сум хороонд хөтөлбөрт хамрагдах ажил олгогч цөөн байна. Улирлын чанартай ажлын байр нилээд байгаа нь тогтвортой нэг жилээс дээш хугацаагаар гэрээ хийх боломжгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

2.37 ХЭҮЗ-ийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны 4 дүгээр тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг баталсан байна. Хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн ажлын байр бий болгоход зориулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн дэмжлэг, урамшуулал, санхүүжилт олгоход хөтөлбөрийн зорилго чиглэгдсэн байна.

2.38 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох сонгон шалгаруулалтыг ХЭҮТ-өөс зохион байгуулж санхүүжүүлсэн байна. ХБИ-д аж ахуй эрхлэхэд нь зориулж 10.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосныг хүснэгтээр үзүүлбэл;

Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Зөрүү /сая төгрөг/
Төлөвлөсөн зардал /сая төг/	Хамруулсан хүний тоо	Гүйцэтгэсэн зардал /сая төг/	Хамруулсан хүний тоо	
200.0	2570	101.7	1395	98.3

2.39 Төсөлд хамрагдах иргэн нь эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэртэй байх, дангаараа болон бусадтай хамтран аж ахуй, бизнесийн төсөлтэй байх, аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлж, хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ бичгээр илэрхийлсэн байх зэрэг шалгуурыг бүрэн хангасан иргэд цөөн байснаас шалтгаалан 98.3 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2.40 Хөтөлбөрийн үр дүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хувиараа хөдөлмөр эрхлэх зорилгоор өрхийн үйлдвэрлэл үйлчилгээндээ оролцож санхүүгийн дэмжлэг авснаар өрхийн орлогоо нэмэгдүүлэх, бизнесээ өргөжүүлэх боломж нэмэгдсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд 1366 иргэн байнгын ажлын байртай болж, өрхийн орлого нэмэгдсэн бөгөөд үүнээс 1089 хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- Хөтөлбөрт хамрагдсан 91 иргэн тусгайлсан ажлын байраар хангагдсан байна. Тусгайлсан ажлын байранд харааны бэрхшээлтэй 12 иргэн, сонсголын бэрхшээлтэй 16 иргэн, тулгуур эрхтэний бэрхшээлтэй 37 иргэн, саажилттай 3 иргэн тогтвортой ажлын байртай болсон байна.

2.41 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад Говь-Алтай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээний 3.2-т заасан “Төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулна” гэснийг зөрчиж хөтөлбөрт хамрагдсан 20 хөгжлийн бэрхшээлтэй иргэний 11 төслийн 11000.0 мянган төгрөгийн тайлан ирүүлээгүй, Ш.Цэрмаа 1000.0 мянган төгрөг, Ц.Үүрцайх 1000.0 мянган төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан нийт 13000.0 мянган төгрөгийн зөрчил гарсан байна.

2.42 Энэ хөтөлбөрт хамрагдахад тавигдаж байгаа шалгуур болон хөтөлбөрийн үр өгөөжийн талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд танилцуулах, шалгуурт заагдсан баримт бичгийг бүрдүүлэхэд нь хөдөлмөрийн хэлтсийн ажилтнуудаас тусламж үзүүлэх ажлыг хангалтгүй хийж байна.

Дөчөөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

2.43 МУЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ХЭҮЗ-ийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны 4 дүгээр тогтоолоор 40-өөс дээш болон мэргэжлийн өндөр ур чадвартай ахмад настны дадлага туршлагатай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг баталсан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Зөрүү /сая.төг/
Төлөвлөсөн зардал /сая.төг/	Хамруулсан хүний тоо	Гүйцэтгэсэн зардал /сая.төг/	Хамруулсан хүний тоо	
1020.0	5000	643.5	3354	376.5

2.44 2013 онд Хөтөлбөрт хамрагдсан иргэдэд олгох санхүүгийн дэмжлэг харьцангуй бага байсан, мөн ажил олгогчдод олгох урамшуулалыг олгох хугацаа болоогүйгээс 376.5 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2.45 Хөтөлбөрийн үр дүнд:

- Хөтөлбөрт хамрагдсан иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд оруулж, бүртгэсэн ба хөтөлбөрийн арга хэмжээнд нийт 4304 иргэн хамрагдаж, 2252 иргэн ажлын байранд зуучлагдсан. Ахмад настай мэргэжлийн өндөр ур чадвартай 639 иргэн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн 40-өөс дээш насны 2541 иргэн сургалтад хамрагдаж мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн ба үүнээс 933 иргэн хувиараа аж ахуй эрхэлж байна.

2.46 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад орон нутгийн хэмжээнд дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд;

- **Төв аймагт:** 40-өөс дээш хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэний хамруулах хөтөлбөрт хамрагдсан иргэдийн материалаас ХХ-ийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй 3 иргэнд 600.0 мянган төгрөгийг олгосон;
- **Хан-Уул дүүрэгт:** ХЭДТХ-ийн 3-т заасан хөтөлбөрт заасан санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрт хамрагдах иргэний бодит хэрэгцээнд үндэслэн купоноор дамжуулан олгоно гэж заасныг зөрчин зориулалт бусаар 16400.0 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч нөөцөлсөн;
- **Баян-Өлгий аймагт:** Хөтөлбөрөөс 1600.0 мянган төгрөгийг гарын авлага хэвлүүлэх, хяналтын зардалд, 5.500.0 мянган төгрөгийг байгууллагад контейнер худалдан авахад, мөн үйл ажиллагааны зардалд 39.2 сая төгрөгийг зарцуулсан;
- **Булган аймагт:** Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн ажилд зуучлагдсан, ажил хайгч иргэдийн бүртгэлтэй тулгаж үзэхэд 96 иргэний 14 нь ажил зуучлагдсан буюу ажилтай болсон, 29 иргэн нь ажил идэвхтэй хайж байгаа, 23 иргэн нь ажил идэвхгүй хайж байгаагаар бүртгэлтэй байгаа, 30 иргэн эдгээр бүртгэлийн алинд нь ч бүртгэлгүй байгаа тул тэдгээр иргэдэд зарцуулсан 6000.0 мянган төгрөгийг төлүүлэхээр болсон байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд иргэн Х.Саранчимэгт 347.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн;
- **Увс аймагт:** Дадлага туршлагатай иргэдээр нийтэд мэдээлэл, зөвлөгөө өгүүлэх, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах замаар тухайн иргэнд үйлчилгээний хөлсийг олгохдоо ХХОАТ тооцоогүй болох нь тогтоогдож нийт 2800.0 мянган төгрөгийн зөрчил илэржээ.

2.47 Хөтөлбөрийг дүгнэхэд 40-өөс дээш насны иргэдийг ажлын байраар хангах хүсэлтэй ажил олгогч, ажлын байр хөдөө орон нутагт цөөн байгаагаас шалтгаалан хөтөлбөрийн хэрэгжилтэд хамрагдах иргэдийн тоо бага байна.

2.48 Ахмад настны зөвлөгөө өгөх үйлчилгээ нь голдуу залуучуудад, өсвөр насны иргэдэд зориулсан чиглэлээр тооны хичээл заах, зөвлөгөө өгөх хэлбэрээр явагдаж байгаа тул ажилгүй иргэд зөвлөх үйлчилгээнд хамрагдахгүй байна.

Эзэнтэй монгол хөтөлбөр

2.49 Нийтийн эрх ашгийг хангах бүтээн байгуулалтын болон ногоон хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах, эх орныхоо газар нутгийг хайрлан хамгаалах, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах, хог хаягдлыг цэвэрлэх, эрсдлээс сэргийлэх зэрэг үйл ажиллагааг эрхлэх иргэдийн бүлгийг дэмжих замаар иргэний хариуцлагыг өндөржүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад хөтөлбөрийн зорилго чиглэгсэн байна.

2.50 Аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтсүүд орон нутагтаа хэрэгжүүлэх нийтийг хамарсан болон ногоон ажлын байр бий болгох төслүүдийг хүлээн авч Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөрөө хэлэлцүүлэн сонгон шалгаруулалт хийж, шалгарсан төслүүдийг хэрэгжүүлж байна.

2.51 “Эзэнтэй монгол” хөтөлбөрийн хүрээнд урт хугацаанд 3-10 сар хүртэлх ажлын байр бий болгох төслүүдийг туршилтаар хэрэгжүүлдэг байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр үзүүлбэл:

Төлөвлөсөн		Гүйцэтгэл		Зөрүү /сая/
Төлөвлөсөн зардал/тэрбум/	Хамруулсан хүний тоо	Гүйцэтгэсэн зардал/сая/	Хамруулсан хүний тоо	
4600.0	36700	4166.7	60647	433.3

2.52 Ногоон ажлын байранд урамшуулал, санхүүгийн дэмжлэгийг төсөл хэрэгжүүлсний дараагийн жилд олгодог учир 433.3 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2.53 Хөтөлбөрийн үр дүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эзэнгүй, харьяалах байгууллагагүй байсан хог хаягдал, бохирдол ихтэй газруудыг иргэд, нөхөрлөл бүлэгт хариуцуулан өгч байгаль орчныг хамгаалах чиглэлээр ногоон ажлын байрыг бий болгосон. Энэ хүрээнд улсын хэмжээнд 619 ажлын төслийг хэрэгжүүлж, 2216 ажлын байр бий болгосон;
- Нийтийн эзэмшлийн гудамж тайлбай хариуцан ажиллах иргэдийн бүлгийг аймгийн төвд байгуулж, цэцэрлэг, ногоон талбай бүхий газруудад 3-5 сар хүртэлх хугацаанд иргэдийг ажиллуулж байнгын ажлын байраар хангасан. Гудамж, тайлбай хариуцан ажилласан 156 бүлэг нөхөрлөл улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулсан;
- Хөдөө орон нутгийн ажилгүй залуучуудыг байгаль орчныг хамгаалах бүлгийн үйл ажиллагаанд оролцуулж хөдөлмөр эрхлээгүй байсан 35 хүртэл насны 784 залуучууд төсөлд хамрагдсан байна.

2.54 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад гарсан хүндрэл бэрхшээлийн талаар дурдвал:

Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн өдрийн хөлсийг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ажлын өдөрт хувааж ажлын хөлсийг олгож байгаа нь өдрийн 12500 төгрөг байгаа нь иргэдийн оролцоо, сонирхлыг бууруулж байна.

2.55 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад орон нутгийн хэмжээнд дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- **Завхан аймагт:** Нийтийг хамарсан ажлын үр дүнг шалгах явцад Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн нийтийг хамарсан ажилд оролцсон иргэдийн мэдээллийг гаргаж ирүүлээгүй учраас тухайн ажлууд хийгдсэн нь нотлогдоогүй, орлогын албан татвар суутгаагүйгээс 3400.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн; Нийтийг хамарсан нийт 58.0 сая төгрөгийн ажил гэрээт хугацаанд хийгдээгүй;
- **Хэнтий аймагт:** Нийтийг хамарсан ажлын зардлаас байгууллагын конторын засварын ажил, 31200.0 мянган төгрөг, мөн ажилтай орлотой Хэнтийчүүд уулзалтад 500.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- **Өвөрхангай аймагт:** сангийн хөрөнгөөр Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагааны зардалд 4.4 сая төгрөгийг зарцуулсан;
- **Говь-Алтай аймагт:** Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэдийн цагийн бүртгэлгүй байхад 4.3 сая төгрөг олгосон;
- **Архангай аймагт:** Байгаль хамгаалах сан болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тендер зарлагдсан 7 ажилд нийтийг хамарсан ажлаар хүмүүс ажиллуулсан нэрийдлээр 9400.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон мөн ажлыг төсвийн дагуу хийгээгүй, хувь хүний эзэмшлийн газарт нийтийг хамарсан ажил хийсэн зэрэг 2 ажлын 3300.0 төгрөг нийт 12700.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн;
- **Баян-Өлгий аймагт:** Энэхүү хөтөлбөрөөс нийтдээ 16000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаар илэрсэн нийт төлбөр зөрчлийн талаар:

2.56 Аудитаар аймаг, нийслэлийн 3 дүүргийг хамруулсан нийт хөтөлбөрийн хүрээнд сангийн хөрөнгийг зориулалт бусаар 583.8 сая төгрөгийн зөрчил аудитаар илэрсэн болно. Зөрчлийг задлан харуулбал 162.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 421.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Хүснэгтээр аймаг, нийслэлийн аудитын газраас тавьсан акт, албан шаардлагын жагсаалтыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Аймгийн нэрс	акт		Албан шаардлага	
		тоо	Дүн /сая.төг/	тоо	Дүн /сая.төг/
1	Архангай	2	12.7		
2	Баян-Өлгий	3	16.0	2	44.7
3	Булган	3	6.3	1	0.8
4	Говь-Алтай	5	84.9	4	96.3
5	Дархан-Уул	5	17.2		
6	Завхан	11	3.4	2	60.6
7	Орхон	3	2.8	2	48.0
8	Өвөрхангай			3	21.1
9	Сүхбаатар	2	5.6	3	72.7
10	Сэлэнгэ			1	25.0
11	Төв	1	0.6		
12	Увс	2	2.8		
13	Ховд	1	0.36		
14	Хэнтий	1	0.5	2	31.7
15	Нийслэл	10	9.6	2	20.2
	Нийт	49	162.7	22	421.1

Бүлэг 3. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл болон орон нутгийн салбар зөвлөл, дотоод хяналт шинжилгээний талаар

3.1 Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл болон орон нутгийн салбар зөвлөл нь дүрэмд заагдсан эрх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 ХЭҮЗ-ийн үйл ажиллагааны 2013 оны санхүүжилтийг 200.0 сая төгрөг байхаар төлөвлөж гүйцэтгэлээр 183.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

3.3 Аймаг, нийслэл дүүргийн салбар зөвлөлүүдэд тус бүр 4.0 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс дэмжлэг болгон өгч хамтран ажилласан бөгөөд хурлын зардалд 3.0 сая, хуралдааны үйл ажиллагааны зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.4 2013 онд ХЭҮЗ-ийн “Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр”-үүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, “Эзэнтэй монгол” хөтөлбөр, “40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэлэлцэн баталсан бөгөөд 2013 оны төсвийн төслийн талаар Хөдөлмөрийн сайдад зөвлөмж гаргаж ажилласан байна.

ХЭҮЗ-ийн зохион байгуулсан ажлуудыг дурьдвал:

- Аймаг, нийслэлийн Хөдөлмөрийн бага чуулган зохион байгуулсан;
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний чуулган зохион байгуулсан;
- Дорнод, Сэлэнгэ, Завхан, Дархан-Уул аймагт орон нутгийн ажил олгогч байгууллагуудтай хамтарсан хэлэлцүүлэг семинарыг 2 өдөр зохион байгуулж гурван талын төлөөлөл бүхий 50 хүн оролцуулав;
- БНСВУ-д болсон Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний байгууллагуудын дэлхийн холбооны хуралд төлөөлөгчдийг оролцуулсан;
- Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдэд үнэлгээ хийж шинэчлэх, шинэ хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн орон нутаг, дүүрэгт ажиллуулсан;
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хуралдааныг 2 удаа нэг удаагийн хуралдааныг нийслэлийн салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулав.

3.5 Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт аудитаас илэрсэн зөрчил болон сангийн төлөвлөсөн хөрөнгө бүрэн зарцуулагдаагүй байдлаас харахад ХЭҮЗ нь ЗГ-ын 2011 оны 350 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм”-д заасан эрх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөтөлбөр төслийн хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй. ХЭДС-ийн орлого зарлагын байдалд хяналт тавих үүргээ биелүүлж ажиллаагүй байна.

Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлын талаар

- **Говь-Алтай аймгийн салбар зөвлөл** нь “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.1-д зааснаар 4 үйл ажиллагааг явуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэснийг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж ажиллаагүй байна. 2013 оны хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймагт ХЭД дэд сангийн төсвийг бүрдүүлээгүй, нийтийг хамарсан ажил болон хөдөлмөрт бэлтгэх сургалтад ажил хөдөлмөр эрхэлдэг иргэдийг хамруулсан зэрэг зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн аудитын газраас өгсөн боловч зөвлөлийн хурлаар огт хэлэлцээгүй, Дээрх зөрчил дахин давтагдан гарч байна. Мөн салбар зөвлөлийн үүрэгт зааснаар ХЭДС-ийн орлого, зарлагад хяналт тавьж ажиллаагүй, хөдөлмөр эрхлэлтийн төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, сайжруулах эрчимжүүлэх тодорхой ажил хийгээгүй байна
- **Сүхбаатар аймгийн салбар зөвлөл** нь 3 удаа хуралдаж, МХЭД хөтөлбөрт хамрагдах сум, ХБХ-ийн санхүүгийн дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, иргэд, 40-өөс дээш болон ахмад насны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зөвлөгөө өгөх

ахмадыг сонгох, сумдад хийгдэх НХА-ын төслүүдийг хэлэлцэж батлах, 8 хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлантай танилцсан боловч үнэлгээ дүгнэлт, тайлан гаргаж, шийдвэрлэсэн асуудлаа баталгаажуулаагүй байна. ХЭСЗ-ийн үйл ажиллагаа оновчтой байж чадахгүй байгаа ба ХЭСЗ-ийн дүрмийн 3.7¹² -г зөрчин 1620.0 мянган төгрөгийн урамшууллыг илүү олгосон зөрчил илэрлээ.

- **Нийслэлийн салбар зөвлөл нь** Салбар зөвлөлийн дүрэм болон Хөдөлмөрийн сайдын дээрх тушаалд зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллыг хуралдааны оролцоог харгалзан олгохоор заасан ч “оролцоо” гэдгийг ямар шалгуураар авч үзэх, ямар албан тушаалтны шийдвэрээр, хэрхэн тооцож олгох талаар тодорхой зааж өгөөгүйгээс зөвхөн хуралдааны ирцийг үндэслэн ХХ-ийн даргын тушаал, ХЭСЗ-ийн даргын шийдвэрээр урамшууллыг олгосон байна.
- Аудитад хамрагдсан БЗД, БГД, ХУД-ийн ХЭСЗ-ийн хурлын тэмдэглэлд гишүүдийн дэвшүүлсэн санал, дүгнэлт, хурлаас гарсан шийдвэрт тусгагдсан хэдий ч тэдгээрийн хэрэгжилт тодорхойгүй, ХЭАНДЗД-ийн 2.1.110, 2.1.211-д заасан эрх үүргийг хэрэгжүүлэх талаар хийгдсэн үр дүнтэй ажлууд байхгүй байна.
- **Орхон аймгийн салбар зөвлөл нь** сурталчилгаа бэлтгэхэд урьдчилгаа 600.0 мянган төгрөг зарцуулахыг зөвшөөрсөн хурлын протокол, ямар нэгэн шийдвэр, гэрээ хэлцэл хийгээгүй, нотлох баримтгүй МСҮТ-ийн төрийн сан дахь дансруу шилжүүлсэн, мөн зөвлөлийн зардлаас 270.0 мянган төгрөгийг шагналд зарцуулсан байна. Энэ нь *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөлийн эрх үүрэг, бүрэн эрхт “Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгож болох бөгөөд урамшууллын хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно/* гэж заасныг зөрчин шагнал урамшуулал олгосон, сурталчилгаанд хөрөнгө зарцуулсан байна.
- **Өвөрхангай аймагт:** Зөвлөлийн зардлаас болон сангийн санхүүжилтээс нийт 780.0 мянган төгрөгийг хоолны зардал зарцуулсан.

Булган аймагт: Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2012 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 тоот тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3-ын 7 дахь “Зөвлөлийн гишүүдэд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээгээр хуралдааны оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгож болно” гэсэн заалтын дагуу нэг хүнд нэг удаа 100.0 мянган төгрөгөөр тооцож ХХОАТ-ыг суутган тооцсоноор 3 удаа 9 хүнд нийт 2430.0 мянган төгрөг олгосон боловч ХХОАТ-т суутгасан 270.0 мянган төгрөгийг төсөвт төлөөгүй байсанд сангаас нөхөн төлүүлэхээр болсон.

Дотоод хяналт, шинжилгээ хийгдэж байгаа ч хангалтгүй байна

3.6 Хөдөлмөрийн яам болон орон нутгийн салбарын үйл ажиллагаанд санхүүгийн талаас нь дотоод аудит хийгдэж байгаа ч төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хангалтгүй байна.

3.7 Хөндлөнгийн аудитаар хөдөлмөрийн хэлтсүүдийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 31 байгууллагад 3 хувийн аудитын компаниудаас аудит хийж зөрчилгүй 31, хязгаарлалттай 3 байгууллага, төлбөрийн акт 4 байгууллага, албан шаардлага 7 байгууллагад тавигдсан байна.

12 “Зөвлөлийн гишүүдэд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээгээр хуралдааны оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгож болно”

Илэрсэн зөрчил дутагдалын талаар:

- **Нийслэлд:** ХЭД арга хэмжээнд хамрагдсан иргэдийг бүртгэл, мэдээллийн санд бүрэн бүртгэж, мэдээллийг шинэчилсэн эсэх, ажилд зуучлах үйлчилгээний үр дүнд ажлын байраар хангагдсан эсэх, мэргэжлийн болон үйлдвэр дээрх сургалт явуулсан, сургалтын зардал авсан ААНБ суралцагчдын 70-аас доошгүй хувийг ажлын байраар хангасан эсэх, нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлж ажиллуулж байгаа эсэхэд тавих хяналт хангалтгүй байна. Түүнчлэн иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлж, урамшуулал олгон, хөтөлбөр арга хэмжээнд хамруулснаар хэдэн ажлын байр бодитоор бий болсон, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг тооцсон судалгаа, мэдээлэл байхгүй байна.
- **Дундговь аймагт:** Дотоод хяналтыг хийхдээ урьдчилан боловсруулсан хөтөлбөр, төлөвлөгөө, удирдамж байхгүй, шалгуур үзүүлэлтээ бэлдээгүй, тухайн төсөл хөтөлбөрийн үр дүнг үнэлээгүй байна. Дотоод хяналтын аргачлалыг хөтөлбөрийн зорилго, үр дүн, төсөл сонгон шалгаруулахад баримтлах шалгууруудтай уялдуулж боловсруулаагүй. Дотоод хяналтын ажлын үр дүнг тооцоогүй. Дотоод хяналтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, цаашдын зорилго, зорилтоо боловсруулж ажиллаагүй байна.
- **Төв аймагт:** Сангаас олгогдож байгаа зарцуулалтад дотоод хяналт шалгалт огт хийгдээгүй байгаа ба аймгийн хөдөлмөрийн хэлтсийн дотоод хяналт шалгалт хариуцсан мэргэжилтний тайлбараар зээл олголт орой хийгдсэн учраас зээлийн ашиглалт бүрэн хэрэгжиж эхлээгүй учраас 2014 онд хяналт шалгалтыг хийхээр төлөвлөсөн байна.
- **Хэнтий аймагт:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн хөтлөгдвөл зохих анхан шатны баримтын бүрдлийг сайн бүрдүүлж ажилласан боловч сангийн хөрөнгөнөөс засварын зардалд зарцуулсан, хөрөнгө бэлтгэсэн чуулга уулзалтад оролцсон иргэдийн тоглолтын билетийн зардлыг сангийн хөрөнгөнөөс гаргасан, зэрэг зөрчлүүд илэрсэн нь сангийн хөрөнгөд тавих дотоод хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгааг харуулж байна.
- **Завхан аймагт:** 2013 онд Хөдөлмөрийн хэлтсээс 3 удаагийн хяналт шалгалтыг 5 сумыг хамран гүйцэтгэжээ. Тайлант онд Хөдөлмөрийн хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт “хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- **Говь-Алтай аймагт:** Тайлант онд малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан Алтай, Бигэр, Дэлгэр, Тайшир, Есөнбулаг сумдаар явж малжуулсан өрх, иргэдийн малыг газар дээр нь тоолон шалгасан боловч үр дүнг тооцоогүй байна. Эзэнтэй монгол хөтөлбөр, ХХЭ болон НХ байгуулах иргэнийг дэмжих, сургалт зохион байгуулах, ажилд зуучлах, ХБИ-г дэмжих хөтөлбөрт сангийн зүгээс хяналт хийсэн гэх боловч хяналт хийсэн баримт материал байхгүй байна. Хөдөлмөрт бэлтгэх, ажил олгогчийг дэмжих, эзэнтэй монгол хөтөлбөр, 40-өөс дээш насны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт огт хяналт тавиагүй байна.
- **Орхон аймагт:** Хяналтын зардлаас 1.8 сая төгрөгийн зургийн аппарат худалдаж авсан, мөн 457.0 мянган төгрөгийг шатахуунд зарцуулсан.
- **Булган аймагт:** Хяналт, үнэлгээ хийх төсвөөс сумдад ажиллаж төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, зээл ашиглалтад хяналт хийх томилот, шатахууны зардалд 4993.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй, хяналт хийснээр ямар зөрчил, дутагдал илрүүлж засуулсан, ямар арга хэмжээ авч төсөл хөтөлбөрийн үр дүнг сайжруулсан талаар баримтжуулсан зүйл байхгүй байна.

3.8 ХЭДС-ийн хөтөлбөр тус бүрд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх талаар тусгасан заалт байгаа ч биелэлт нь хангалтгүй байгааг аудитын явцад илэрсэн зөрчил, дутагдалаас харж болохоор байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дунд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Сангийн хөрөнгө төвлөрүүлэлт 2013 онд 7.9 тэрбум төгрөгөөр тасалдсан байна.
2. Аж ахуйн нэгж, байгууллагууд ЗГ-ийн 2009 оны 26 дугаар тогтоолд заасан “Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрийг сар бүр төлөх” заалтыг мөрдөж ажиллаагүйгээс ойролцоогоор 3 тэрбум төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлээгүй байна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл болон орон нутгийн салбар зөвлөл нь орлого, зарлагын байдалд хяналт тавих нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
4. Дотоод хяналт шалгалтыг хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцох үнэлэх талаас нь хангалттай ажил зохион байгуулаагүй байна.
5. ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих явцын хяналт хангалтгүй, зохион байгуулж байгаа арга хэмжээ, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр нь богино хугацааны, түр зуурын шинж чанартай, үйлдвэрлэл дээрх сургалт, эрхийн бичгийн сургалт болон богино хэмжээний сургалт, нийтийн хамарсан ажлын хүрээнд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа боловч үр нөлөө бага байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Хөдөлмөрийн яамны сайд Я.Санжмятавт:

1. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрийг хэрхэн төвлөрүүлэх энэ талаар гаргасан ЗГ-ын 2009 оны 26 дугаар тогтоолыг биелүүлэх талаар холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах,
2. Хөтөлбөрийн үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдалыг цаг хугацаанд арилгуулах талаар хөдөлмөрийн хэлтсийн дарга нарт үүрэг болгох, тавигдсан актыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага иргэдээс гаргуулж барагдуулах,
3. Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зарим төсөл хөтөлбөр халамжийн шинж чанартай байгааг анхаарч ажиллах,
4. ХЭДС-ийн хөрөнгийг аль болох далайцтай бүтээн байгуулалтын ажилд чиглүүлж, ажилгүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, тогтвортой ажлын байраар хангах нөхцлийг судлаж шийдвэрлэх.



**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас: 26-15-69, Факс: (976-51) 26-14-15,
E-mail: info@mol.gov.mn, http://www.mol.gov.mn

2014. 06. 24 № д/1544

танай _____-ны № _____-т


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
А.ЗАНГАД ТАНАА

Танай газраас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2013 оны үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитын урьдчилсан дүгнэлттэй танилцаж холбогдох тайлбарыг хавсралтаар хүргүүллээ.

Хүлээн авч тайлбар, тодруулгыг нягтлан судлана уу.

Хавсралт *2* хуудастай.

ДЭД САЙД



Ж.БАТХУЯГ

802772

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТАЛААР

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2013 оны үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцаад дараах саналтай байна.

1. Нэр томъёо:

1. Тайлангийн бүх хэсэгт Хөдөлмөрийн хэлтсийн нэрийг хуучин нэрээр Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс /ХХҮХ/ гэсэн байгааг Хөдөлмөрийн хэлтэс гэж өөрчлөх,
2. Аудитын нэр: Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны үр дүн гэсэн байгааг засах

2. Гарчигийн талаар:

Монгол Улсын хэмжээний ажилгүйдлийн түвшин 2013 онд 2012 онтой харьцуулахад 7,9 хувь болж 0,3 пунктээр буурсан статистик мэдээ гарсан байгаа бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад ихээхэн үр нөлөөгөө өгдөг юм.

Хэдийгээр ажилгүйдлийг бууруулах нь макро түвшний бодлого болон олон арга хэмжээний үр дүнд бий болох үзүүлэлт боловч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд бий болсон ажлын байрны тооноос харахад сангаас зарцуулсан хөрөнгө үр ашигтай чиглэсэн бодлогоо хэрэгжүүлсэн байгааг анхаарч тайлангийн ерөнхий нэрийг эргэн харах.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын бүрдүүлэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогын тооцоог хийж, 9,9 тэрбум төгрөгийн орлого олох боломжийг алдсан гэж дүгнэсэн байна.

Хөдөлмөрийн яамны харъяа Хөдөлмөрийн хэлтсүүд нь аж ахуйн нэгж байгууллагуудыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөрийг төлөөгүй тохиолдолд хянаж шалгах, торгууль тавих эрх бүхий субъект биш юм. Мэргэжлийн хяналтын байгууллагын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид энэхүү үүргийг хүлээн ажиллаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн хэлтсүүд нь эдгээр Хөдөлмөрийн улсын байцаагчтай хамтран ажиллаж байгаа боловч, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхи, хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа тодорхой шалтгаанууд байсаар байна. Түүнчлэн Үндэсний статистикийн газрын мэдээгээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгжүүдийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллуулаагүй төлбөрийн орлого жилд 3,0 тэрбум гаруй төгрөгөөс хэтрэхээргүй тооцоо гарч байдаг тул дээрх тооцоо, дүгнэлтийг нягталж өөрчлөх.

4. Хамрах хүрээ, дүгнэлтийн талаар:

Аудитын тайланд хамарсан хүрээг Хөдөлмөрийн яам болон Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Баянгол дүүргийн ХХҮХ гэсэн байна. Аудитын тайлан нь аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүд, харъяа байгууллагуудыг бүхэлд нь хамарсан байгаа бөгөөд зорилт, дүгнэлт, зөвлөмжинд ороогүй Хөдөлмөрийн төв биржийн хэрэгжүүлсэн ажил, дансны гүйлгээ, Сайдын тушаалын хавсралт зэргийг хавсаргасан нь ойлгомжгүй байна. Иймд тайлангийн хавсралт хэсгийг хасах саналтай байна.

Мөн Бүлэг 1-ийн 1.4-д “урьд оны төсөл, хөтөлбөрөөс зарцуулагдаагүй 6,2 тэрбум төгрөгийн үлдэгдэл гарсныг төсөвт эргэн төвлөрүүлээгүй байна.” гэсэн нь Хөдөлмөрийн хэлтсүүд оны эцсийн үлдэгдэлийг санхүүгийн тайлан баланст тусган Сангийн яам татан төвлөрүүлж дараа онд эх үүсвэрт тооцон Сангийн Сайдын тушаалаар буцаан олгодог болно.

5. Хамарсан хугацааг тодорхой болгох

Нийцлийн Аудитын хамрах хугацаа нь 2013 он гэж байгаа боловч Хөдөлмөрийн төв биржийн 2012 онд хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг аудитын дүгнэлтэнд тусгасан нь ойлгомжгүй байна.

**ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ
САНХҮҮ, САНГИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР**

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлангийн төсөлд
ХЯ-наас ирүүлсэн саналд өгсөн тайлбар:**

1. Хөдөлмөрийн хэлтсийн нэрийг хуучин нэрээр Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс /ХХҮХ/ гэсэн байгааг Хөдөлмөрийн хэлтэс гэж өөрчлөх саналыг хүлээн авч тайланд тусгав.
2. Үндэсний статистикийн мэдээгээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллуулаагүй төлбөрийн орлого жилд 3.0 тэрбум төгрөгөөс хэтрэхээргүй байна гэснийг хүлээн авч тайланд тусгав.
3. Тайлангийн хавсралт хэсгийг хасах санал ирүүлснийг хүлээн авлаа.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсүгэй.
4. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хамжээ авч, үр дүнг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн сайд, Хууль зүйн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга нарт зөвлөсүгэй.
5. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД